



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 9/60

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Засаг даргын нэрэмжит
цэрэг-спортын “Дөл-2025” цогцолбор
тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.3.3, 4.4.3.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл-2025” цогцолбор тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Зэвсэгт хүчний 084 ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсугай.

2.Тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тэмцээний удирдамжийг хоёрдугаар, зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тэмцээнд оролцох дасгалжуулагч, тамирчдыг эрүүл мэндийн анхан шатны үзлэгээр оруулахыг Эрүүл мэндийн төв (Х.Ганцэцэг)-д, аюулгүй арга хэмжээг сахиулж, удирдлага арга зүйгээр ханган, сахилга, зохион байгуулалттай оролцуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа Б.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

4.Тэмцээний зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Лхагвасүрэн)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1505010193

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 18-ны өдрийн 1/180 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:

Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга

Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн
хэлтсийн дарга

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга

Дүүргийн Улаан загалмайн хороон дарга

Нарийн бичгийн дарга:

Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын
Төлөвлөлт, сургалтын офицер

---oOo---